

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ  
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2021 он**

## АГУУЛГА

### Удиртгал

#### 1.Төлөвлөх үе шат

- 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- 1.2. Үнэлгээ хийх хүрээг тодорхойлох
- 1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох
- 1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг тодорхойлох

#### 2.Хэрэгжүүлэх үе шат

- 2.1.Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах
- 2.2.Холбогдох субъектээс судалгаа авах

#### 3.Үнэлэх үе шат

- 3.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

#### 4.Дүгнэлт, зөвлөмж

## УДИРТГАЛ

Биеийн тамир, спортын салбар 2003 онд хуультай болж төрийн зохицуулалт, дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж, биеийн тамир, спортоор хичээллэх иргэдийн хамрах хүрээ нэмэгдэж, спортын төрөл, хэлбэрүүд нэмэгдэхийн хирээр төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлэх, иргэдийн спортоор хичээллэх орчин нөхцөл сайжруулах зэрэг олон төрлийн харилцаа зохицуулах шаардлага бий болсноор 2017 онд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт **“Энэ хуулийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө”** гэж заасан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг **“Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухай хуулийн тогтоомжийг дагаж мөрдсөнөө хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно”** гэж заасан үндэслэн Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлээ.

Шинэчлэн батлагдсан хуулиар биеийн тамир, спортын салбарын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулан иргэдийн сонирхол, хандлага, хэрэгцээнд тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх бие бялдрын мэдлэг, боловсрол олгох, салбарын хүний нөөцийн мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх, тэдгээрийн нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлсэн болно.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгаар спортын холбоодын эрх үүргийг тодорхойлсон бөгөөд төрийн төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд спортын холбоодод төрийн тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлж гүйцэтгүүлэх, олон улсын жишгийн дагуу спортыг бизнесийн зарчмаар хөгжүүлэх, спортод хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, хандив, хөрөнгө оруулалтад бодит дэмжлэг үзүүлэх замаар салбарын төсвийн бус эх үүсвэрийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгосон.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд 2018 оноос үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үндэсний хэмжээний спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээн, Монгол Улсад зохион байгуулагдах тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээнийг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг Спортын мэргэжлийн холбоодод гэрээний дагуу шилжүүлдэг болсон.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд Улсын Их Хурлын 2020 оны “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” 07 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хороог байгуулсантай холбогдон Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байгаа бөгөөд Монгол Улсын Их хурлын 2021 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 12 дугаар тогтоолын хавсралтын 1.1-ны 4 дэх

хэсэгт “Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцүүлэхээр тусгуулсан ба Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна.

## **НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 2.1 дэх хэсэгт заасны дагуу үнэлгээ хийх ажиллагаа нь:

1. Төлөвлөх;
2. Хэрэгжүүлэх;
3. Үнэлэх гэсэн 3 үе шаттай байна.

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.1 дэх хэсэгт заасны дагуу төлөвлөх үе шатанд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасны дагуу дээрх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүллээ.

### **1.1. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШАЛТГААНЫГ ТОДОРХОЙЛОХ**

Монгол Улсад орчин цагийн биеийн тамир, спорт 100 орчим жил хөгжил байгаа бөгөөд олон улсын чанартай тэмцээн наадамд оролцох, олон улсын спортын хамтын нийгэмлэгийн бүрэх эрхт гишүүн болохыг хувьд НҮБ-ын Бие бялдрын боловсрол, спортын харт, Олон улсын олимпын харт, НҮБ-ын спорт дахь допингийн эсрэг конвенцод нэгдэн орсон байдаг.

Биеийн тамир, спортын салбарын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эдийн засаг, эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнд оролцогчдын харилцааг зохицуулах зорилгоор УИХ-аас Биеийн тамир, спортын тухай хуулийг анх 2003 онд баталсан ба 2007 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортоор хичээллэх орчин, шигшээ багийн асуудлаар, 2009 онд биеийн тамир, спорт чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэл, мөнгөн урамшууллын асуудлаар, 2012, 2016 онд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй уялдуулан нэмэлт, өөрчлөлт 4 удаа хийгдсэн.

Биеийн тамир, спортын хөгжилд төрийн дэмжлэг, зохицуулалт нэмэгдсэнээр 2008 онд 44 жил хүлээсэн олимпын аваргатай болж, хүүхэд залуучууд, иргэдийн спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэж, биеийн тамир, спортын төрөл, хэлбэрүүд олширч биеийн тамир, спортоор хичээллэгч, сонирхогч, дэмжигчдийн тоо

улам бүр өссөн ба биеийн тамир, спортын хөгжлийг олон улсын чиг хандлагад ойртуулан иргэдийн хандлага, бие бялдраа хөгжүүлэх мэдлэг боловсролыг дээшлүүлэх, салбарын хүний нөөцийн мэргэжил, ур чадвар, тэдгээрийн нийгмийн хамгааллын асуудал өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх эрх зүйн зохицуулалт дутагдаж байсан.

Мөн биеийн тамир, спортын үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу спорт бизнесийн зарчмаар хөгжүүлэх, спортод хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хандив, хөрөнгө оруулалтад бодит дэмжлэг үзүүлэх замаар салбарын төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төрийн тодорхой чиг үүргийг спортын мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох шаардлага тулгараад байна.

Түүнчлэн биеийн тамир, спортыг хүний хөгжлийн болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр болгон хөгжүүлэх олон талт зорилтыг дэвшүүлсэн НҮБ-ын 1977 оны “Бие бялдрын боловсрол, спортын харт”, НҮБ-ын 2011 оны “Халдварт бус өвчний асуудлаарх Улс төрийн тунхаглал”, Олон Улсын Олимпын Хорооны “Спортыг бүхний төлөө” зорилт, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2013 онд баталсан “Берлиний Тунхаглал”-аар гишүүн улс орнуудад дээрх зорилтыг хангах, хүний хөгжлийн эрхэд тулгуурласан үндэсний тогтолцоо бий болгон бэхжүүлэхийг зөвлөмж болгож байсны дагуу боловсруулсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд УИХ-аас баталсан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжээд 4 жил болж байгаа ч Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэг **“Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухай хуулийн тогтоомжийг дагаж мөрдсөнөө хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно”** гэж заасан, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 02 дугаар тогтоол, Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал дүгнэлт гаргах, шийдвэрийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн удирдамжийг үндэслэл болж байна.

## 1.2. ҮНЭЛГЭЭ ХИЙХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын дагуу үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгдсэн байдаг.

Энэ нь үнэлгээ хийх болсон дээр дурдсан шалтгаануудтай харилцан уялдаа холбоо, хамааралтайгаар хийх ажиллагаа бөгөөд хуулийг хэрэгжүүлэх явцад илэрсэн эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлэх зорилготой.

Үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо хуулийг бүхэлд нь, эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болох бөгөөд “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.3.3 дахь заалтад заасны дагуу үнэлгээний хүрээг тогтоохдоо үнэлгээ хийх ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөц, цаг хугацаа, гарах зардлыг заавал харгалзан үзэх шаардлагатай байдаг.

Хуулийн зохицуулалтыг бүхэлд нь үнэлэх ажиллагаа нь хэт өндөр зардалтай, хугацаа их шаарддаг бөгөөд ихэвчлэн үнэлгээний хүрээг тухайн үнэлгээ хийхээр сонгосон хуулийн хамгийн чухал ач холбогдолтой, хуулийн хэрэгжилтэд гол нөлөөлөл үзүүлэх зохицуулалтуудыг дараах байдлаар сонголоо. Үүнд:

#### **Үнэлгээний хүрээ 1**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 2 дугаар бүлэг.**

*“Биеийн тамир, спортын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс уг салбарыг зохицуулах арга зам, тэдгээрийн хэрэгжилт”*

#### **Үнэлгээний хүрээ 2**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 3 дугаар бүлэг.**

*“Байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамир, спортын үйл ажиллагааны чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт”*

#### **Үнэлгээний хүрээ 3**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр бүлэг.**

*“Спортын үйл ажиллагааны хэрэгжилт”*

#### **Үнэлгээний хүрээ 4**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 дугаар бүлэг.**

*“Биеийн тамир, спортын үйл ажиллагааны улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилт, төсвийн бус санхүүжилт, хөрөнгө оруулалт үйл ажиллагааны хэрэгжилт,”*

### **1.3. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОЖ ТОГТООХ**

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д заасны дагуу шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн байх шаардлагатай бөгөөд аргачлалын 3.4 дэх хэсэгт заасан 6 шалгуур үзүүлэлтээс дээр сонгож авсан үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой байх шаардлагад мөн нийцүүлсэн.

#### **Шалгуур үзүүлэлт**

Зорилгод хүрсэн түвшин буюу тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх

#### 1.4. ХАРЬЦУУЛАХ ХЭЛБЭРИЙГ СОНГОХ

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.5.1 дэх заалтад заасны дагуу хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашиглана.

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь заалтад заасан 4-н төрлийн харьцуулах хэлбэрээс дараах хэлбэрийг сонголоо:

<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Харьцуулах хэлбэр</b>
Зорилгод хүрсэн түвшин	Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар (одоо байгаа нөхцөл байдал)-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хууль тогтоомжоор тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хууль тогтоомжийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

#### 1.5. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОМЬЁОЛОХ

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.6.1 дэх заалтад заасны дагуу тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлж, эсхүл асуулт тавьж шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар томьёоллоо.

<b>Сонгосон шалгуур үзүүлэлт</b>	<b>Шалгуур үзүүлэлтийг томьёолсон байдал</b>
Зорилгод хүрсэн түвшин	Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь зорьсон зорилгодоо хүрсэн эсэх

## **1.6.МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГЫГ ТОДОРХОЙЛОХ**

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.7.3.1 дэх дэд заалтын дагуу мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалж болон биеийн тамир, спортын салбарын байгууллагын үйл ажиллагааны тайлан, спортын холбоо, спортын клубийн үйл ажиллагааны тайланд шинжилгээний хийх, тэдгээрийн дунд зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд гаргаж байсан саналыг ашиглан мэдээлэл цуглуулна.



## ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

### ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 1

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 2 дугаар бүлэг.**

“Биеийн тамир, спортын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс уг салбарыг зохицуулах арга зам, тэдгээрийн хэрэгжилт”

#### **Шалгуур үзүүлэлт**

Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/

#### **Харьцуулах хэлбэр**

Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар

#### **Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал**

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь зорьсон зорилгодоо хүрсэн эсэх

#### **Үнэлсэн байдал**

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгжилт

### **6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх.**

6.1.Засгийн газар нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.биеийн тамир, спортын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;

6.1.2.биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, батлах, хэрэгжүүлэх;

6.1.3.иргэний нас, хүйс, хэрэгцээ сонирхолд нийцсэн биеийн тамир, спортын төрлийг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр батлах;

6.1.4.үндэсний спорт, багийн спортын төрлийг хөгжүүлэх хөтөлбөр батлах;

6.1.5.улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах талаар шийдвэрлэх, зохион байгуулалтын журам батлах;

6.1.6.тухайн жилд Монгол Улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтыг батлах;

6.1.7.энэ хуулийн 6.1.4, 6.1.5, 10.1.4-т заасан тэмцээн, наадмыг зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам батлах;

6.1.8.Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам батлах.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд нийт 14 бодлогын болон эрх зүйн баримт бичиг батлахаас одоогийн байдлаар 11-ийг баталсан ба 2 журам, 1 дүрмийг батлах боловсруулалтын ажил хийгдэж байна.

Засгийн газрын тогтоолоор дараах баримт бичиг, журмын баталсан.Үүнд:

- Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого /2019 он/
- Биеийн тамир, спортын хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /2019 он/
- Гаалийн албан татвараас чөлөөлөх спортын зориулалт бүхий тоног төхөөрөмж, хэрэглэлийн жагсаалт /2019 он/
- Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам /2018 он/
- Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам /2020 он/
- Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам. /2018 он/
- Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд эрүүл мэндийн даатгалын урамшуулал олгох журам /2019 он/

Биеийн тамир,спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дараах журмуудыг баталсан. Үүнд:

- Спортын сургалт дасгалжуулалт удирдах, спортын тэмцээнд оролцуулах, үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журам /2018 он/
- Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам /2018 он/
- Спортын клубийг магадлан итгэмжлэх журам /2019 он/
- Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам /2019 он/

Засгийн газрын тогтоол болон Биеийн тамир,спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дараах баримт бичиг, журмын батлуулна. Үүнд:

- Допингийн эсрэг Үндэсний дүрэм батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл
- “Улсын хэмжээний спортын тэмцээн, наадам зохион байгуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам” батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл
- “Улсын хэмжээнд спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангилал тогтоох журам”

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хугацаанд хяналт хийх холбогдох зөвлөмж, дүгнэлтээр ханган ажиллаж байна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоолоор “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд 2019-2027 оны хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Биеийн тамир, спортыг хүн амын зөв амьдралын хэв маяг, эрүүл аж төрөх ёсны хэрэглээ, ажиллах чадварыг дээшлүүлэх хэрэглүүр болгох;
- Үндэсний шигээ багийн бүх түвшинд тамирчдын ур чадварыг ахиулах, тив, дэлхий олимпод өрсөлдөхүйц чадварыг бий болгох спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог боловсронгуй болгох;
- Спортын шинжлэх ухаан болон анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх;
- Биеийн тамир, спортын салбарт зохистой түншлэл, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог сайжруулах, санхүүжилтийн бодлогыг боловсронгуй болгох;

Дээрх бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 23 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд Биеийн тамир, спортын улсын хороо нь “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнадаг. “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар 86.09 хувьтайгаар үнэлсэн байна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 335 дугаар тогтоолоор “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ыг баталсан бөгөөд 2020-2023 онд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн. Үүнд:

- Хүн амын зорилтот бүлгүүдийн сонирхол, бодит хэрэгцээнд нийцсэн биеийн тамир, спортын үйл ажиллагаа, бие бялдрын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;
- Спортын шинжлэх ухаан, анагаах ухааны судалгаа, шинжилгээ, туршилтад суурилсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх суурь тогтолцоог бүрдүүлэх;
- Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төрийн зарим чиг үүргийг олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн спортын холбоо, түүний

аймаг, нийслэл, дүүргийн салбар, магадлан итгэмжлэгдсэн спортын клубээр гүйцэтгүүлэх;

- биеийн тамир, спортын санхүүгийн менежментийг сайжруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар төсвийн бус санхүүжилтийг нэмэгдүүлэх.

Дээрх зорилтууд нь бодлогын баримт бичигт дурдагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдаатай бөгөөд Биеийн тамир, спортын улсын хороо нь “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнадаг. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 85,22 хувьтайгаар үнэлсэн байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 335 дугаар тогтоолоор “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ыг баталсан ба үндэсний спорт, багийн спортын төрлийг хөгжүүлэх нийтлэг байдлаар тусгагдсан.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ыг баталсан. Тус журмаар дор дурдсан наадмыг зохион байгуулахаар тусгаж, тэдгээр наадмын зохион байгуулалтын харилцааг бүрдүүлсэн.

№	Наадмын нэршил	Төрөл	Зохион байгуулагдах давтамж	Зохиогдож эхлэх он
1	Монголын бүх ард түмний спортын наадам (паралимп, дифлимпын төрлийг оролцуулна).	Зун	4 жил тутамд	2021 оноос
		Өвөл		2019 оноос
2	Үндэсний спортын наадам	Зун	4 жил тутамд	2018 оноос
		Өвөл		
3	Монголын Оюутны спортын наадам	Зун	2 жил тутамд	2020 оноос
		Өвөл		
4	Монголын хүүхдийн спортын наадам (паралимп, дифлимпын төрлийг оролцуулна).	Зун	2 жил тутамд	2019 оноос
		Өвөл		

“Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-аар тухай жилд зохион байгуулагдах наадамтай холбоотой холбогдох шийдвэрийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гарган хэрэгжүүлж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсад зохион байгуулагдах олон улсын тэмцээний жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор баталж, Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулалт болон шаардагдах санхүүгийн дэмжлэгийг спортын холбоодод үзүүлэн ажиллаж байна.

Монгол Улсад 2018 онд 12 спортын төрлийн олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын холбоодтой хамтран зохион байгуулж, 1.1 тэрбум төгрөг санхүүгийн дэмжлэг, 2019 онд 13 спортын төрлийн олон улс, тивийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын холбоодтой хамтран зохион байгуулж, 1.3 тэрбум төгрөг санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Дэлхийн нийтийг хамарсан цар тахлын улмаас 2020 онд Монгол Улсад олон улсын чанартай тэмцээн зохион байгуулагдаагүй.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

“Улсын хэмжээний спортын тэмцээн, наадам зохион байгуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын төслийг боловсруулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авах үйл ажиллагаа явагдаж байна.

Тус харилцааг одоогийн байдлаар Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-аар зохицуулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”, хоёрдугаар хавсралтаар “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ыг тус тус шинэчлэн баталсан.

Олон улсын чанартай болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцсон тамирчин, түүний дасгалжуулагч нарт олгосон мөнгөн шагналын зардалд 2015-2020 онуудад 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

**7 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх**

7.1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
---

7.1.1.биеийн тамир, спортын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, хяналт тавих;

7.1.2.эдийн засгийн тооцоо, материаллаг бааз, хүний нөөцийн судалгаан дээр үндэслэн нутаг дэвсгэртээ улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах талаар нэр дэвших эрх авах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэх;

7.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог дэмжих.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлд орон нутгийн өөрөө удирдах байгууллагын биеийн тамир, спортыг орон нутагт хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бүрэн эрхийг тодорхойл, орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр батлах, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, түүнд хяналт тавих зэрэг бүрэн эрхийг хуульчилж өгсөн байна.

Одоогийн байдлаар аймаг, нийслэл, дүүргүүд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт биеийн тамир, спортыг хөгжүүлэх тодорхой зорилт, арга хэмжээг тусган, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Мөн тухай орон нутгийн онцлогийг харгалзан биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр тусгайлсан хөтөлбөрийг 15 аймаг, дүүрэг батлан, орон нутгийн төсөв, засаг даргын нөөц хөрөнгөөс хөтөлбөрийн санхүүжилтийг жилд 30-150 сая төгрөгийн зарцуулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Уг зохицуулалт нь орон нутагт үндэсний хэмжээний наадам зохион байгуулах харилцааг олон улсад наадам зохион байгуулагдах жишигт нийцүүлэх, дотоодын аялал жуулчлал, орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжихэд чиглэсэн харилцаа бөгөөд тус харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 3 дугаар бүлгээр нарийвчлан зохицуулсан.

Одоогийн байдлаар орон нутагт үндэсний хэмжээний наадам зохион байгуулагдаагүй байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Орон нутагт биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог дэмжих чиглэлд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь хэсэгт “Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив”-ыг албан татвар ногдох орлогоос хасаг бусад зардалд, мөн тус хуулийн 22 дугаар

зүйлийн 22.5.5 дахь хэсэгт “Биеийн тамир, спортын тухай хуулийн 26.2-т заасан стандартыг хангасан спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг” гэж албан татварын хөнгөлөлт тус тус хамруулснаас гадна орон нутгийн хэмжээнд алдаршуулах, сурталчилах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

## **8 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх**

8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.харьяа нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

8.1.2.харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

8.1.3.биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;

8.1.4.суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах;

8.1.5.биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах;

8.1.6.хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх;

8.1.7.биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах;

8.1.8.аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, чөлөөлөх.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Аймаг, нийслэлийн засаг дарга нь энэ хууль болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар дараах төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэх чиг үүргийг тодорхойлсон бөгөөд түүний 27.5.9 дэх хэсэгт “нийтийн биеийн тамир” чиг үүргийг гүйцэтгэхээр зохицуулсан.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх биеийн тамир, спортын байгууллагын байгуулан биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.6 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.9 дэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.6 дахь хэсэгт иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэхээр зохицуулсан болно.

Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.6 дахь хэсэг нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дугаар зүйлийн 21.1.16 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1.17 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.8 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь хэсгүүдтэй уялдах бөгөөд харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн спортын барилга, байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээг тухай шатны засаг дарга хамаарсан эрх зүйн орчныг бүрдүүлсэн явдал юм.

Монгол Улсад 2020 оны жилийн эцсийн байдлаар өмчийн бүх хэлбэрийн 686,880 м.кв талбай бүхий 1068 спортын заал, 3,360,288 м.кв талбай бүхий 852 спортын гадаа талбай байгаа нь иргэд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэж байна.

Ийнхүү спортоор барилга, байгууламжийг ашиглалтад орсноор нэг хүнд ногдох спортын заалны талбайн хэмжээ 0,25 м.кв, гадна талбай 1,25 м.кв болсон бөгөөд энэ нь “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ын 2023 онд хүрэх зорилтод түвшнийг хангаад байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.7 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын салбарын олон улсын жишиг зарчим нь төрийн болон спортын холбоодын хамтын ажиллагаа байдаг бөгөөд орон нутгийн биеийн тамир, спортын төрийн байгууллага болон спортын холбоодын хамтын ажиллагаа, уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дах зарчмыг хангуулах зорилгоор уг зохицуулалтууд тусгагдсан болно.

Биеийн тамир, спортын төрийн захиргааны байгууллага болон үндэсний хэмжээний спортын холбоодын хамтын ажиллагаа хангалттай түвшинд байгаа бол орон нутагт төдийлөн идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлэх чиглэд тодорхой ажил хийгдэхгүй байсан.

Дээрх зохицуулалтын хүрээнд өнөөгийн байдлаар орон нутагт зохион байгуулагдах орон нутгийн чанартай болон бүс, улсын чанартай тэмцээн, өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, иргэнийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оруулах, ажил үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагаанд орон нутгийн спортын холбоо, клубын оролцоог нэмэгдүүлж байна.



Мөн иргэнд үзүүлэх биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхлэдэг иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, дугуй, ролик, тэшүүр, цанын спортын төрлүүдээр үйлчилгээг үзүүлэх цэгийн тоо нэмэгдүүлж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спорт, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг сумын иргэдийн өдөр тутмын хэрэглээ болгох, бие бялдрын боловсрол, мэдлэгийг олгох биеийн тамирын арга зүйчийг 299 суманд ажиллуулах эрх зүйн орчныг тус зохицуулалтаар бүрдүүлсэн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.2.1 дэх хэсгийн 2-т үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусган ажиллаж байна. Тус төлөвлөгөөгөөр 2022 онд 50 арга зүйч, 2023 онд 90 арга зүйч, 2024 онд 130 арга зүйчийн ажлын байрыг шинээр бий болгоно.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газар нь тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх биеийн тамир, спортын зорилт, үйл ажиллагааг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн хүрээнд батлуулан, хэрэгжүүлж байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрийг санхүүжилтэд аймаг, нийслэл, дүүрэг тус бүр орон нутгийн төсөв, засаг даргын нөөц хөрөнгөөс жилд 30-150 сая төгрөгийн зарцуулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Уг зохицуулалт нь биеийн тамир, спортын төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах, шаардлага хангасан хүний нөөцийг томилж ажиллуулах зорилгын хүрээнд бүрдүүлсэн зохицуулалт хэдий ч тус зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байна.

## 9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1.бие бялдын боловсролыг дэмжих, бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамирын хичээлийн сургалтын агуулга, стандарт, хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг тогтоохдоо биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг тусгах;

9.2.2.бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь сургалтын агуулга, стандарт, хичээлээс гадуурх сургалтын ажлын хөтөлбөрийг зөрчин суралцагчдад биеийн тамир, спортын заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийг төлбөртэй ашиглуулахыг хориглох;

9.2.3.боловсролын сургалтын байгууллага, суралцагчдын сургуулийн орчинд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үндэсний стандартад нийцсэн биеийн тамир, спортын заал, талбай, хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

9.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.3.1.хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг идэвхтэй хөдөлгөөн, спортоор дамжуулан зохион байгуулах;

9.4.Эрүүл мэндийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.4.1.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтад хамрагдах магадлан итгэмжлэгдсэн спортын клубийн нэрсийг хүргүүлэх.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 1-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” А/491 дугаар тушаал, 2019 оны 8 дугаар сарын 1-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” А/492 дугаар тоот тушаалаар бага, дунд, ахлах ангийн биеийн тамир хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн баталсан.

Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2019 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” А/514, А/736 дугаар тушаалаар “Хүүхдийн биеийн жин, өндрийг бүртгэх, тандах журам”-ыг батлан боловсролын байгууллага болон эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтийг хэрэгжүүлэх хүрээнд:**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтийг хэрэгжүүлэх хүрээнд:**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтийг хэрэгжүүлэх хүрээнд:**

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн “Журам заавар батлах тухай” 487 дугаар тушаалаар нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам”-ын 7.2.1-т “бие бялдар засал”, хоёр дугаар хавсралтаар батлагдсан “Сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ын 5.2-т заасан “Сэргээн засах тусламж, үйлчилгээнд зонхилон хийгдэх эмчилгээний нэр төрөл”-д хүний биеийн бүтэц, үйл ажиллагааны алдагдлын улмаас үүссэн үр дагаврыг арилгахад чиглэсэн сэргээн засах тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг идэвхтэй хөдөлгөөн, спортоор дамжуулан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Улсын их хурлаас Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлахдаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд тодорхой нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн спортын клубт 3 сар тогтмол хичээллэж өвчлөлөөс урьдчилан сэргийлсэн иргэд спортоор хичээллэсэн төлбөрийн тодорхой хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал хэлбэрээр олгох эрх зүйн орчныг Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.7, 3.1.8, 9 дүгээр зүйлийн 9.1.12, 9.4 дахь хэсгээр зохицуулж байсан бөгөөд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

Улсын хэмжээн 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 16 спортын клуб магадлан итгэмжлэл авсан ба эдгээр спортын клубт 3 сарын хугацаанд тогтмол хичээллэж эрүүл мэндийн даатгалын сангаас 60 мянган төгрөгийн урамшуулал авах болзол хангасан 3000 гаруй иргэн байна.

**10 дугаар зүйл. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

10.1.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.биеийн тамир, спортын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

10.1.2.биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, холбогдох бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах;

10.1.3.бие бялдрын түвшин тогтоох стандартыг боловсруулан, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх;

10.1.4.улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах спортын холбоог сонгон шалгаруулах;

10.1.5.улсын хэмжээнд зохион байгуулах спортын наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, тэмцээний зохион байгуулалтыг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;

10.1.6.эрхэлсэн сайдын баталсан биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журмын хэрэгжилтийг хангах;

10.1.7.эрхэлсэн сайдын баталсан улсын төсвөөс дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журмын хэрэгжилтийг хангах;

10.1.8.биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх;

10.1.9.хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажлыг зохион байгуулах;

10.1.10.бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

10.1.11.допингийн эсрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

10.1.12.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх;

10.1.13.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын удирдлага, зохион байгуулалтаар хангаж, холбогдох нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтийн хангуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоолын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хугацаанд хяналт хийх холбогдох зөвлөмж, дүгнэлтээр ханган ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамирын, спортын чиглэлээр давхардсан тоогоор 126 байгууллага, иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж, биеийн тамир, спортын мэргэжил, арга зүйн зөвлөмж, удирдлагаар ханган ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил” нь 2014 оны батлагдаж байсан хүний биеийн 5 чанарыг тодорхой дасгал гүйцэтгүүлэх замаар үнэлдэг аргачлал юм. Тус аргачлалыг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд мөрдөгдөх стандарт болгон батлуулах эрх зүйн зохицуулалтыг тус хуулиар бүрдүүлсэн.

Энэхүү аргачлалыг сайжруулах судалгаа 2018-2019 онуудад хийсэн бөгөөд нийгмийн хэрэгцээ шаардлага, олон улсын байгууллагын зөвлөмжийн дагуу хүний биеийн биометрийн үзүүлэлтийг тодорхойлох, түүнд тулгуурлан 5 чанарын тодорхой дасгал гүйцэтгүүлэх замаар үнэлдэг аргачлалыг боловсруулж байна.

Мөн шинэчлэн боловсруулж буй уг аргачлалыг цахим суурьтай болгох, мэдээллийг цахим платформд нэгтгэх асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Спортын төрлийн сонгон шалгаруулах үзүүлэлт, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай” А/53 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Спортын холбоодод улсын төсвийн хөрөнгөөр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох шалгуур үзүүлэлт”-ийн дагуу улсын төсвөөс санхүүжүүлэх улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах спортын холбоог сонгон шалгаруулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын дагуу улсын хэмжээнд зохион байгуулах спортын наадмын хөтөлбөрт багтах спортын төрлийг тогтоох, тэмцээний зохион байгуулалтыг арга зүйн удирдлагаар ханган, хяналт тавин ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн “Журам

батлах тухай” А/319, А/176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам ”-ын дагуу хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Журам батлах тухай” А/167 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”, хоёрдугаар хавсралтаар “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг тус тус баталсан. Энэхүү журмын дагуу Үндэсний шигшээ багийг 22 спортын төрлөөр барьж тухайн спортын холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын мэдээллийн санг хөгжүүлэх ажлын хүрээнд техник эдийн засгийн үндэслэлийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулан “Идээдэвэллопмент” ХХК Биеийн тамир, спортын цахим сангийн программ хангамжийг боловсруулах Биеийн тамир, спортын газрын 202001007 дугаартай гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд Системийн хөгжүүлэлт, түүний дэд системүүдийн хөгжүүлэлт, байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлт гээд нийт 7 дэд системийн хөгжүүлэлтийн хийн 100%-ын гүйцэтгэлтэй ажиллаж байна. Системийн хөгжүүлэлт болон засвар үйлчилгээний ажил нь 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл гүйцэтгэгч байгууллага “Идээдэвэллопмент” ХХК хариуцан ажилласан. Системийн хөгжүүлэлтийн хүрээнд харьяа 32 байгууллага болон холбоодод системийн танилцуулга, хэрхэн ашиглах талаар цахим хурлыг 3 удаагийн давтамжтай зохион байгуулан, гарын авлагаар ханган ажиллаж байна.

Салбарын мэдээллийн нэгдсэн цахим санг хөгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ:

2017 онд статистикийн үзлэг тооллогоо 50 сая төгрөг,  
2018 онд сургалт, гадаад дотоодын экспертийн зардал нийт 20 сая төгрөг,  
2019 онд цахим сангийн ТЭЗҮ баримт бичиг боловсруулах ажилд 45.7 сая төгрөг,  
2020 онд программ хангамж боловсруулах ажилд 236.7 сая төгрөг,  
2021 онд салбарын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд 447.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Цаашид төрийн байгууллагын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх болон тэдгээрийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-mongolia-д холбох талаар үе шаттай ажлуудыг төлөвлөн хэрэгжилтийг зохион байгуулж байна. Үүнд:

2022 оноос спортын цол зэргийн лавлагаа,

2023 оноос Биеийн бялдрын түвшин тогтоох сорилын лавлагаа,  
2024 Монгол улсад зохион байгуулагдсан наадам, тэмцээний үр дүнгийн лавлагаа авах зэрэг ажлуудыг E-mongolia системд нэвтрүүлэхээр төлөвлөж байна.  
Эдгээр ажлуудыг амжилттай хэрэгжүүлснээр мэдээллийн цахим санг бүрдүүлэх үйл ажиллагаа хэрэгжиж салбарын хэмжээний удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа цахим суурьтай болох нөхцөл бүрдэх ба ингэснээрээ судалгаанд суурилсан бодлого төлөвлөлт хийгдэх үндсэн нөхцөл бүрдэх боломжтой болно.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай” 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дүгээр сарын 21-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 335 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлэн хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажилд хяналт тавин ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн “Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай” 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай” 391 дүгээр тогтоолоор “Спортод допинг хэрэглэхийн эсрэг олон улсын конвенцыг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд допингийн эсрэг мэдээлэл, сургалт, сурталчилгаа, судалгаа хийх, урьдчилан сэргийлэх, допингийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн шинжилгээ авах, баталгаажуулах, үр дүнг тооцох ажил”-ыг Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагаар гүйцэтгүүлж, тус тогтоолын 1 дэх заалтын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн “Зардал батлах тухай” А/65 дугаар тушаалаар Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Допингийн эсрэг үндэсний дүрмийн төслийг боловсруулан ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого батлах тухай” 153 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ын

- 4.1.6 дахь заалт биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн ажлын байр бий болгох, бүртгэл, мэдээллийг сайжруулах.
- 4.4.4 дахь заалт Спортыг дэмжих сангийн хөрөнгийг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдийг дэмжихэд түлхүү зарцуулах;

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дүгээр сарын 21-ны өдрийн “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 335 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн

- 2.2.2 дахь заалт спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах;
- 3.2 дахь заалт Спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоог хөгжүүлж, төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдыг олимп, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах зорилтын хүрээнд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:
- 3.4.1 дэх заалт аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх;
- 3.5.4 дахь заалт хүн амд үзүүлэх биеийн тамирын ажил үйлчилгээ, спортын амжилтын үр дүнд суурилан төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх системийг бүрдүүлэх, хяналт тавих тогтолцоог сайжруулах.

Дээрхи заалтуудыг тус тус хэрэгжүүлэн төр өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэн ажиллаж байна.



## **Үнэлгээний хүрээ 2**

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 3 дугаар бүлэг.**

*“Биеийн тамир, спортын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс уг салбарыг зохицуулах арга зам, тэдгээрийн хэрэгжилт”*

### **Шалгуур үзүүлэлт**

*Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/*

### **Харьцуулах хэлбэр**

*Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар*

### **Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал**

*Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь зорьсон зорилгодоо хүрсэн эсэх*

## **Үнэлсэн байдал**

### **11 дүгээр зүйл. Спортын холбооны чиг үүрэг**

11.1.Спортын холбоо нь тухайн спортын төрлийг дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, төлөөлөгчийн газар, салбар, спортын клубээр дамжуулан иргэнд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Спортын холбоо нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн спортын төрлийн олон улсын холбооны дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

11.3.Спортын холбоо нь дараах эрх, үүрэгтэй байна:

11.3.1.спортын тэмцээний дүрэм, заавар, тухайн жилийн спортын тэмцээний хуваарь батлах;

11.3.2.улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарьт оруулах тэмцээний саналаа хүргүүлэх;

11.3.3.спортын тухайн төрлөөр олон улсын болон улс, бүсийн чанартай тэмцээн зохион байгуулах;

11.3.4.дасгалжуулагч, спортын шүүгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, олон улсын дүрмийн дагуу тухайн спортын төрлөөр дасгалжуулагч, спортын шүүгчээр ажиллах эрхийг хязгаарлах, хасах;

11.3.5.спортын тэмцээн, наадмын үед олон улсын дүрмийн дагуу тоглолтын үр дүнд нөлөөлөхүйц үйлдэл, эс үйлдэл гаргасан тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчийн тухайн спортын тэмцээн, наадмын үйл ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах, хасах;

11.3.6.олон улсын холбооноос гаргасан тэмцээний болон шүүлтийн дүрмийг мөрдүүлэх, тамирчны ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

11.3.7.тамирчны сургалт-дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулах, шигшээ баг бүрдүүлэн спортын тэмцээн, наадамд оролцуулах;

11.3.8.холбооны бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулсан спортын тэмцээн, наадам, тамирчны амжилт, спортын цол, зэрэг, гишүүнчлэлээр мэдээллийн цахим сантай байх;

11.3.9.тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

**Биеийн тамир спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**


Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах эрх бүхий спортын холбоо нь төрийн бус байгууллагын тухай хуулийн 4.2, 5, 6 дахь

Биеийн тамир, спортын тухайн хуулийн 10.1.12 энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх гэсэн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:

1. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын судалгааг гаргаж улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг 1722 байгууллагын үйл ажиллагааны хэлбэр, нэршил, бүртгэлийн дугаар байршлын судалгааг гаргав.

Үүнээс спортын клубын чиглэлээр 309 төрийн бус байгууллага үйл ажиллагаа эрхэлж

- гишүүдэд үйлчлэх төрийн бус байгууллага нь 68,
- нийтэд үйлчлэх төрийн бус байгууллага 241,
- дэвжээ нэршлээр 35,
- сургалтын төв 4,
- “төв” нэршлээр 34,
- зөвлөл 32,
- нийгэмлэг 34,
- академи 17,
- оноосон нэр бүхий төрийн бус байгууллага 329,
- спортын холбоо 928 байгааг ангилан гаргасан.



**Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1, 11.3.2, 11.3.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**


11.3.1. Спортын холбоод тухайн жилд зохион байгуулах улс, бүсийн тэмцээний хуваарийг гарган хуулийн 11.3.2 заасны дагуу биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж, 11.3.3 заасны дагуу тухайн спортын төрлөөр улс, бүсийн чанартай тэмцээнийг зохион байгуулах нэгдсэн хуваарийн дагуу тэмцээн, наадмыг зохион байгуулж байна.

Тухайн жилд зохион байгуулагдах улс, бүсийн тэмцээнд Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2009 оны 53/45 тоот тушаал “Спортын наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу эрх авсан спортын холбоодод санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

### 2018 , 2019 онуудад зохион байгуулагдсан улсын хэмжээний спортын тэмцээний төрөл



### улсын хэмжээнд зохион байгуулагдсан тэмцээн



2019 онд зохион байгуулагдах 54 спортын холбоодын өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн УАШТ-ний 180 хуваарийн саналаа хүргүүлж ирүүлсэн. 2020 онд 55 спортын холбоодын өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн 217 УАШТ-н зохион байгуулах хуваарийн саналаа хүргүүлж ирүүлсэн. 2021 онд зохион байгуулагдах улсын хэмжээний тэмцээний нэгдсэн хуваарийг батлуулахаар 67 спортын төрлийн 4 насны ангиллын 194 удаагийн тэмцээний хуваарийг батлуулахаар саналаа хүргүүлсэн. **2018 онд улсын төсвийн санхүүжилт, Засгийн газрын тогтоолоор олон улсын чанартай 11 тэмцээнийг 1 тэр бум нэг зуун сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулсан. 2019 онд улсын төсвийн санхүүжилт, Засгийн газрын тогтоолоор олон улсын чанартай 13 тэмцээнийг 1 тэр бум жаран хоёр сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулсан.**

2020 онд Цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой МУ-д олон улсын чанартай тэмцээн зохион байгуулалт хийгдээгүй байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.4, 11.3.5, 11.3.6 заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Дасгалжуулагч эрх олгох, сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаа болон тамирчин, спортын шүүгчийн цол зэрэг олгох заалтуудын хэрэгжилтийг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/839 “Спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журам”, Биеийн тамир, спортын газрын даргын 2018 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/192 дугаар тоот тушаал “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол зэрэг олгох журам”-аар тус тус зохицуулан хэрэгжилтийг хангаж байна. Мөн дасгалжуулагч, спортын шүүгч, тамирчин ёс зүйн зөрчил гарган тэмцээн наадамд оролцох эрхийг олон улсын дүрмийн дагуу хасаж, хязгаарлаж байна. Монгол улсын хэмжээнд хэрэгжих тамирчин, дасгалжуулагч, спортын шүүгчийн ёс зүйн дүрмийг олон улсын дүрэмд нийцүүлэн боловсруулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.8 заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

2020 онд спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсээс үндэсний шигшээ багийн бус спортын төрлөөр улсын төсвийн санхүүжилтээр ОУ-ын чанартай тэмцээн, наадамд 4 тэмцээний ангиллаар 8 спортын төрлөөр 55 тамирчин, дасгалжуулагчдад 145.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Салбарын хэмжээнд цахим мэдээллийн санг ажиллуулж мэдээллийг цуглуулан цахим санд байршуулах ажил эрчимтэй явагдаж спортын 31 холбоодтой хамтран ажиллаж цахим сангийн өгөгдөл бүрдүүлэн ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.9 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 97 тоот тогтоолоор “ Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль, хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ыг баримтлан амжилт гаргасан тамирчин, түүний дасгалжуулагчийг нэг удаагийн болон сар бүрийн мөнгөн урамшууллыг олгож байна. Тамирчин, дасгалжуулагчдад 2020 оны байдлаар давхардсан тоогоор 3881 тамирчинд нийт 1,001,888,115,0 төгрөг олгоод байна.

**12 дугаар зүйл. Спортын клубийн үйл ажиллагаа**

12.1.Спортын клуб нь спортын тухайлсан болон хэд хэдэн төрлөөр үйл ажиллагаа явуулж болно.

12.2.Спортын клуб нь спортын төрлийн дагнасан сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд тухайн спортын төрлийн үндэсний стандартыг, үндэсний стандарт

байхгүй тохиолдолд олон улсын спортын холбооноос гаргасан сургалт-дасгалжуулалтын хөтөлбөрийг мөрдөнө.

12.3.Сургалт дасгалжуулалтын үйл ажиллагааг удирдах, хянах зорилгоор дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйч ажиллуулж, хичээллэгчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол улсын хэмжээнд нэг ба түүнээс дээш чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Спортын салбарын төрийн бус байгууллагын биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1722 байгууллага бүртгэлтэй байгаагаас Улсын бүртгэлийн үйл ажиллагааны хэлбэр, нэршил, бүртгэлийн дугаар байршлын судалгааг гаргасан. Үүнд 309 спортын клубийг үйл ажиллагааны чиглэлээр ангилан гаргаснаар Гишүүнд үйлчлэх ТББ нь 68, Нийгэмд үйлчилгэх ТББ 241 клуб үйл ажиллаа явуулж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/60 дугаар тоот тушаалын хавсралтад Улсын хэмжээнд 16 спортын төрлийн стандартыг мөрдөхөөр тусгасан байгаа. Эдгээрээс бусад спортын төрлүүд олон улсын спортын холбооноос мөрдөж буй стандарт, хөтөлбөрийг дагаж мөрдөн үйл ажиллагаа явуулж байна. /12.3 г нэмэх/

**13 дугаар зүйл. Аж ахуй нэгж, байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

13.1.Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага нь биеийн тамир, спортын чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

13.1.1.ажлын байрны онцлог нөхцөлтэй уялдуулан ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх;

13.1.2.ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх төлөвлөгөө гарган ажиллах, спортын тэмцээн зохион байгуулах;

13.1.3.байгууллагын нийт төсвөөс ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэхэд зарцуулах;

13.1.4.ажиллагсдын бие бялдрын түвшин тогтоох, байгаа түшингээс бууруулахгүй байх, ахиулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

13.1.5.сайн дурын үндсэн дээр биеийн тамирын арга зүйч ажиллуулах.


13.3.Амралтын газар, хүүхдийн зуслан нь амрагчдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын үйл ажиллагаа явуулах орчин бүрдүүлнэ.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

2018 оны байдлаар нийт хамтлагийн тоо 530, үүнээс Төрийн байгууллага 472, Төрийн бус байгууллага 28, Хувьцаат компани 7, Хязгаарлагдмал хариуцлагатай

компани 7, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 2, бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл 2, зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл байна 9. Эдгээр хамтлагаас байгуулагдаад 1-2 жил 267, 3-5 жил 124, 6-9 жил 67, 10-аас дээш жил үйл ажиллагаагаа явуулж буй хамтлаг 72 байна.

Аж ахуй нэгж байгууллагууд дахь хамтлагийн ахлагч нар нь тухайн хамтлагийг сайн дураараа хариуцан ажилладаг.



Биеийн тамир, спортын даргын 2019 оны А/318 дугаар тушаалаар өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх Биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, ажлыг үнэлэх зорилгоор орон даяар зарладаг "Улсын тэргүүний биеийн тамир, спортын хамтлаг" шалгаруулах уралдааны болзлыг нэмэлт өөрчлөлт оруулан "Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага" уралдааны болзол нэртэйгээр 3-н номинацитай байхаар шинэчлэн баталсан. Улсын хэмжээнд шинэчлэн батлагдан зарлагдсан 2019 оны энэхүү болзолт уралдаанд аймаг, нийслэл, дүүргийн 530 аж ахуйн нэгж байгууллагаас шалгарсан 28 байгууллагаас Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага", "Биеийн тамир, спортын хандивлагч байгууллага" номинацид Токио олимп санд 2 тэрбум 500 сая төгрөг хандивласан үзүүлэлтээр Уулын баяжуулах "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын хамт олон; "Биеийн тамир, спортын материаллаг баазыг бүтээгч байгууллага" номинацид Баян-Өлгий аймгийн М.Баглан захиралтай "Понпа" ХХКомпани нь өөрийн 500 сая төгрөгийн хөрөнгөөр олон улсын стандартын 36м x 18м, фитнесийн 6м x 18м чийрэгжүүлэлтийн танхим бүхий "POWER" биеийн тамирын заалыг Өлгий хотноо барьж ашиглалтад оруулан шинээр ажлын байраар хангасан үзүүлэлтээр тус тус шалгарсан. Болзлын дагуу шалгарсан дээрх 9 байгууллагыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын Батламжийн хамт double fish брэндийн олон улсын стандартын шаардлага хангасан ширээний теннисний ширээ болон тоглолтын багц хэрэглэл, олс, дартс, молтен брэндийн сагс, волейболын бөмбөгийг тор, хөл бөмбөг зэрэг спортын хэрэглэлээр урамшуулна. Мөн

шалгарсан 11 байгууллагын тугийг Спортын төв ордны өмнө жилийн турш мандуулж сурталчилсан.

Байгууллагын албан хаагчдын дунд “Чийрэг монгол” сэдэвт биеийн тамирын үйл ажиллагаанд даргын 2020.09.23-ны өдрийн А/16 дугаар тушаалаар 9.341.850 төгрөгийн санхүүжилт батлагдаж үйл ажиллагааг зохион байгуулсан. Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллага дахь спортын дагнасан нэгжүүд нь бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, дасгалжуулалтын үзүүлэлтийг цэргийн албан хаагч, иргэд гэсэн 2 өөр баталсан норм, нормативаар төлөвлөгөөт сургалтын явцад тогтмол тодорхойлж, сургалтын явцад бие бялдрын бэлтгэлжилт, түвшнийг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/62 дугаар тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Амралтын газар, жуулчны баазын МНС 6043:2019 стандартын А хавсралтын “үйлчилгээнд тавигдах шаардлага”-ын 83 дугаар зүйл , Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн С/17 дугаар тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Хүүхдийн зуслангийн МНС 5633:2019 стандартын А хавсралтын 6 дугаар зүйлд заасны дагуу иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлэн ажиллаж байгаа.

#### **14 дүгээр зүйл. Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага дахь биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

14.1.Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллага нь энэ хуулийн 13.1-д зааснаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

14.1.1.спорт нь мэргэжлийн тусгай бэлтгэлийг хангах үйл ажиллагааны салшгүй хэсэг байх, бие бүрэлдэхүүний мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх;

14.1.2.өөрийн үйл ажиллагааны чиглэлээр спортын тэмцээн, наадам зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

14.1.3.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийн тусгай норм, норматив тогтоох, тусгай сургалтын хөтөлбөр батлан мөрдүүлэх;

14.1.4.бие бүрэлдэхүүний бие бялдрын хөгжлийг хангах, спортоор хичээллэх, мэргэжлийн тусгай бэлтгэлийг хангах чиглэлээр спортын дагнасан нэгж ажиллуулах;

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Зэвсэгт хүчний "Алдар" биеийн тамир, спортын хороо, Цагдаагийн Ерөнхий газрын "Хүч" биеийн тамир, спортын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын "Сүлд" биеийн тамир, спортын хороо, Хил хамгаалах Ерөнхий газрын "Хилчин" биеийн тамир, спортын хороо, Тагнуулын Ерөнхий газрын "Эрч" биеийн тамир,



спортын хороо, Онцгой байдлын Ерөний газрын "Аврагч" биеийн тамир, спортын хороо, зэрэг 6 спортын дагнасан нэгж ажиллаж бие бүрэлдэхүүний мэргэжлийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон спортоор хичээллэх нөхцөл боломжийг ханган нийт 14 спорт заалтайгаар ажиллаж байна.

Улсын хэмжээнд "Тусгай байгууллагуудад биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохион байгуулах нь" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг биеийн тамирын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага түүний салбар нэгжүүдийн дарга нар болон онцгой байдал, хууль сахиулах байгууллага дахь спортын нэгж байгууллагын удирдлагууд биечлэн уулзаж асуудлаа хэлэлцэн санал бодлоо солилцон зохион байгуулдаг. Орон нутгийн Биеийн тамир спортын хамтлагийн ахлагч, гишүүдийн дунд "Улсын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллагын биеийн тамир, спортын үйл ажиллагааг хөгжүүлэх биеийн тамир, арга зүйн сургалт семинар"-ыг Даргын 2018 оны А/71 дүгээр тушаалын дагуу зохион байгуулсан. Тус сургаалтанд спортын асуудал хариуцсан мэргэжилтэн, тухайн орон нутаг дахь спортын клуб мөн байгууллага аж ахуйн нэгж дэх Биеийн тамир, спортын хамтлаг, зөвлөлийн төлөөлөгчид хамрагдан салбарын үйл ажиллагаанд баримталж буй бодлоготой танилцсан. Тусгай байгууллагуудын дунд "Чийрэг бие бялдар-Бидний имиж" сэдэвт арга хэмжээг зохион байгуулдаг ба арга хэмжээнд Алдар, Аврагч, Хилчин, Хүч, Эрч, Сүлд гэсэн 6 спорт хороо байгууллага хамрагддаг байгаа.

Биеийн тамир спортын салбарын шинэтгэлийн хүрээнд "Спорт ба хөгжил" сэдэвт сургалтыг зохион байгуулдаг. Мөн биеийн тамирын үйл ажиллагааг жигд, хэвийн үр дүнтэйгээр зохион явуулах, хэрэгжүүлэн ажиллах арга зүйчдэд мэдлэг олгох, эрх зүйн чадамжийг дээшлүүлэх, цаашдын бодлогыг тодорхойлох Зэвсэгт хүчин болон хууль сахиулах байгууллага, спорт клуб, хамтлагийн биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн, арга зүйчдийн "Нэгдсэн сургалт"-ыг зохион байгуулсан.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах /код941/ журам"-ын 941.6 дахь зааснаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага тус бүр дээр 3-аас доошгүй алба хаагчийн бүрэлдэхүүнтэй "Биеийн тамир, спортын хамтлаг" ажиллаж байна. Тус журмын 941.7 дахь заалтад тус хамтлагийн үүргийг тусгасан ба биеийн хамтлагийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тус спорт хороо мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Хамтлагууд байгууллага дээрээ алба хаагчдын бие бялдрын түвшинг тодорхойлох, бие, бялдар бэлтгэлжилтийг зохих түвшинд нь хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээг хариуцан зохион байгуулдаг.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллага дахь цэргийн биеийн тамир, тусгай бэлтгэлийн албанаас жил бүр бие бялдрын бэлтгэлжилтийн норматив тогтоох, тусгай сургалтын хөтөлбөр батлан алба хаагчдаас бие бялдрын бэлтгэлжилтийн нормативаар жил бүр шалгалт авч, цэргийн биеийн тамирын

зааврын дагуу дадлагыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулах /код-941/ журам", "Алба хаагчийг мэргэжлийн зэргийн сургалтад хамруулах, шалгалт авах /код 948/ журам"-уудыг баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дотоодын цэргийн штабаас Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2017 оны А/505 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ыг мөрддөг.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Зэвсэгт хүчний "Алдар" биеийн тамир, спортын хороо, Цагдаагийн Ерөнхий газрын "Хүч" биеийн тамир, спортын хороо, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын "Сүлд" биеийн тамир, спортын хороо, Хил хамгаалах Ерөнхий газрын "Хилчин" биеийн тамир, спортын хороо, Тагнуулын Ерөнхий газрын "Эрч" биеийн тамир, спортын хороо, Онцгой байдлын Ерөнхий газрын "Аврагч" биеийн тамир, спортын хороод нь цэргийн биеийн тамир, тусгай бэлтгэлийн албаны бүрэлдэхүүнийг бүрдүүлж, хилийн анги, тусгай салбарын бүрэлдэхүүнд цэргийн биеийн тамирын сургалт зохион байгуулж, бие бялдрыг хөгжүүлэхэд анхаарч, цэргийн биеийн тамир хариуцсан офицеруудад жил бүр заах арга зүйн сургалтыг явуулж байна.

**15 дугаар зүйл. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа**

15.1.Магадлан итгэмжлэл нь спортын клубийн үйл ажиллагаа, сургалт-дасгалжуулалтын чанарт хараат бус үнэлгээ хийж, мэргэжлийн дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм.

15.2.Спортын клуб нь сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ.

15.3.Спортын клубийг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн хэмжээг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд иргэдийг эрүүл мэндийн даатгалын сангаас даатгуулагчдад төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх ажлын бэлтгэлийг хангах зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллүүлэх, сургалт дасгалжуулалтын чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг, спортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа эрх зүйн чадамжтай хуулийн этгээдийн бүртгэлтэй нийслэлийн 125 клубийн судалгааг гарган Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газарт хүргүүлэн спортын салбарын төрийн бус байгууллагын биеийн тамир, спортын чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг 1722 байгууллагын бүртгэлээс Улсын бүртгэлийн үйл ажиллагааны хэлбэр, нэршил, бүртгэлийн дугаар байршлын судалгааг гаргасан.

Улсын хэмжээнд спортын клубийн магадлан итгэмжлэлийг 2019 оноос эхлэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж шаардлага хангасан 16 спортын клубийн үйл ажиллагаа, сургалт- дасгалжуулалтын чанарт хараат бус шинжээчийн баг жилд 1-2 удаа ажиллан үйл ажиллагаа, сургалт- дасгалжуулалтын чанарт үнэлгээ дүгнэлт өгөн давхардсан тоогоор жилд 35 удаагийн зөвлөгөө зөвлөмжийг өгөөд байна.

Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төр хувийн хэвшлийн түншлэл, иргэдийг халдвар бус өвчнөөс урьдчилан сэргийлж идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх идэвх сонирхлыг дэмжих, тогтмол хичээллэж эрүүл мэндээ сайжруулж байгаа иргэдэд урамшуулал олгох тогтолцоо, олон улсын туршлага, өөрийн орны нөхцөл байдалд зохицуулан эрүүл мэнд, биеийн тамир, спортын салбарын хамтын ажиллагааны үр дүнд стандарт шаардлага ханган, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт 3 сараас дээш хугацаагаар хичээллэж буй иргэд тодорхой хэмжээний урамшуулал олгох тогтолцоог Монгол Улсын Их хурлаас биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд батлахдаа Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар батлагдсан “Спортын клубийн магадлан итгэмжлэлийн журам”-ыг сурталчлахаар нийслэл, дүүргийн Биеийн тамир, спорт хороодын холбогдох мэргэжилтэн, спортын холбоод болон клубийн удирдлага, багш, дасгалжуулагч, биеийн тамирын арга зүйчдийн сургалтыг 2019 оны 7 сарын сарын 19-нд, хараат бус шинжээчдийн сургалтыг 2 удаа, нийт 3 удаагийн сургалт зохион байгуулсан. “Спортын клубийг магадлан итгэмжлэх” Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны 5 сарын 27 өдрийн А/187 тоот тушаалаар “Спортын клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. “Спортын магадлан итгэмжлэл” тараах материалыг боловсруулан 300 ширхэг, “Магадлан итгэмжлэл” гарын авлагыг эмхэтгэн 1400 ширхэг тус тус хэвлүүлж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны “Нээлттэй хаалганы өдөр”-өөр иргэдэд болон фитнесийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад болон сургалтад оролцогчдод олгон сурталчилгааг зохион байгуулсан. “Спортын клубийн магадлан итгэмжлэлийн журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хүсэлтээ ирүүлсэн спорт клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчдийг сонгон шалгаруулж, Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А/313 тушаалаар 20 хүнийг, А/372 тушаалаар 9 хүнийг томилж, нийт 29 хараат бус шинжээчид үнэмлэх олгосон. Спорт клуб, фитнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад мөрдөгдөх нэр бүхий 10 стандартыг эмхэтгэн холбогдох байгууллагаар 100 ширхэг, “Биеийн тамир, спортын хууль эрх зүйн баримт бичиг” гарын авлагыг 300 ширхэг тус тус хэвлүүлж, спортын клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчид, ажлын хэсгийн гишүүдэд, сургалтад оролцогчдод олгон албан хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн. 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 19 дүгээр тогтоолоор Магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд

эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам, урамшууллын хэмжээг тогтоож баталсан. Тухайн эрх зүйн зохицуулалтын хүрээнд эрүүл мэнд, биеийн тамир, спортын салбар төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын түвшинд батлан гаргах бүхийн захиргааны хэм хэмжээг тогтоон, улсын хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 2, Хан-Уул дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Сонгинохайрхан дүүрэгт 2, Сүхбаатар аймагт 1, Орхон аймагт 3, Сэлэнгэ аймагт 1, Дархан-Уул аймагт 1, нийт 16 спортын клубт. магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, тэдгээр 3 сар тасралтгүй хичээллэж буй 3000 гаруй иргэн эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах нөхцөлийг хангаад байна. 2020 оны байдлаар 23 мэргэжлийн багш, 8 эмч, 5 арга зүйч, 5 дасгалжуулагч ажиллаж байна

Одоогоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулийн өөрчлөлт оруулан магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд олгох урамшууллын эрх зүйн зохицуулалтыг хассан бөгөөд 2021 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд 16 спортын клуб магадлан итгэмжлэгдсэн байгаагаас Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт 2, Баянзүрх дүүрэгт 2, Хан-Уул дүүрэгт 2, Сүхбаатар дүүрэгт 2, Сонгинохайрхан дүүрэгт 2, Сүхбаатар аймагт 1, Орхон аймагт 3, Сэлэнгэ аймагт 1, Дархан-Уул аймагт 1 клуб байна. Магадлан итгэмжлэгдсэн 16 фитнес клубүүдэд 2020 оны байдлаар мэргэжлийн 23 багш, 8 эмч, 5 арга зүйч, 5 дасгалжуулагч ажиллаж байна. Эдгээр клубийн мэдээллийг Эрүүл мэндийн даатгалын газарт хүргүүлээд байна.

№	Аймаг, Хот,Сум, Дүүрэг	Спортын клубийн нэр
1	Нийслэлийн Баянгол дүүрэг.	Adrenalin фитнес
2	Улаанбаатар хот. Баянгол дүүрэг	Голден жим 5 салбар
3	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Gold фитнес
4	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг	Голден жим 4 салбар
5	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг	Та-Чи фитнес
6	Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг	МХМ фитнес
7	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг	zaуa,s фитнес
8	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг	Голден жим 1 салбар
9	Улаанбаатар хот Хан-уул дүүрэг	Соёл фитнес
10	Улаанбаатар хот Хан-уул дүүрэг	Эмпайр фитнес
11	Дархан-Уул аймаг	Хар Сүлд фитнес
12	Сэлэнгэ аймаг мандал сум	Титан фитнес клуб
13	Сүхбаатар аймаг	Ханан жим фитнес клуб
14	Орхон аймаг	Максимус фитнес
15	Орхон аймаг	Wise фитнес
16	Орхон аймаг	Макс спиннинг

### **Үнэлгээний хүрээ 3**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр бүлэг.**

*“Спортын үйл ажиллагааны хэрэгжилт”*

#### ***Шалгуур үзүүлэлт***

*Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/*

#### ***Харьцуулах хэлбэр***

*Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар*

#### ***Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал***

*Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь зорьсон зорилгодоо хүрсэн эсэх*

## **Үнэлсэн байдал**

### **16 дугаар зүйл. Сургалт-дасгалжуулалтыг удирдан зохин байгуулах**

16.1.Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн үндэсний шигшээ багийн спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журмыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2.Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургуулийг дасгалжуулагчийн мэргэжлээр төгссөн этгээд нь насанд хүрэгчдийн, залуучуудын үндэсний шигшээ багаас бусад шигшээ баг болон спортын клубт хичээллэж буй тамирчны сургалт-дасгалжуулалт, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагааг эрх авахгүйгээр удирдаж болно.

16.3.Биеийн тамир, спортын боловсрол олгох их, дээд сургуулийг дасгалжуулагчийн мэргэжлээр төгсөөгүй иргэн спортын сургалт-дасгалжуулалтыг энэ хуулийн 16.1-т заасан журмын дагуу эрх авсны үндсэн дээр эрхэлнэ.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/839 дугаар тушаалаар Спортын дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх эрх олгох журмыг батлан гаргасан.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Сайдын 2019 оны А/839 дугаар тушаалаар батлагдсан “Спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журам”, Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А60 дугаар тушаалаар “Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах орон тооны бус зөвлөл”-ийг баталсан. Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын жишиг хөтөлбөр, дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах байгууллага болон багшид тавих шаардлагыг Даргын 2019 оны А/368 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг аймаг, нийслэл, дүүргийн спортын газар, хороо, спортын холбоо, клубтэй хамтран ажиллаж шийдвэрлэсэн.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүний 2020 оны 1 сарын 25 өдрийн хуралдаанаар дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын стандарт хөтөлбөрт нэмэлт

өөрчлөлт оруулан, дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах байгууллага, багшид тавих журмын шаардлагын дагуу сонгон шалгаруулахаар Монгол Улсад биеийн тамир, спортын чиглэлээр боловсрол олгодог их, дээд сургуулиудад зарыг түгээсэн. Сонгон шалгаруулалтад 2020 оны 05 дугаар сарын 22-ний өдрөөр 2020 оны 68,155 тоот албан бичгээр Монгол Улсын Боловсролын их сургууль - Биеийн тамирын сургууль, ҮБТДС хоёр байгууллагаас материалаа ирүүлсэн. Хүсэлт ирүүлсэн сургуулиудын материалыг нэгтгэн Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах орон тооны бус зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн II хуралдаанаар хэлэлцүүлж сургалтыг зохион байгуулах байгууллагаар Монгол Улсын Боловсролын их сургууль -ийн Биеийн тамирын дээд сургуулийг сонгон шалгаруулсан. Сургалтын жишиг хөтөлбөрийн дагуу сонгон шалгаруулж улсын хэмжээнд өсвөрийн насны тамирчинтай ажиллаж буй төгсөлтийн дараах мэргэшүүлсэн сургалтыг эхлүүлэхээр 2020 оны Биеийн тамир, спортын улсын хорооны даргын А тушаалаар Монгол Улсын Боловсролын их сургууль -ын Биеийн тамирын сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Сургалтыг эхлүүлэхээр төлөвлөсөн боловч холбогдох зардлын ангилал Ковид-19 -той хорио цээрийн дэглэм болон төсвийн зардлын хэмнэлтийн горимд шилсэн тул зохион байгуулагдаагүй.

## **17 дугаар зүйл. Спортын тэмцээн, наадам зохион байгуулалт**

17.1. Улсын хэмжээний спортын тэмцээн, наадмыг спортын төрлийн онцлогоос хамаарч сум, дүүрэг, аймаг, нийслэл, бүс, улсын гэсэн шат дараалалтайгаар зохион байгуулж болно.

17.2. Улсын хэмжээний спортын наадмыг Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадмын мөчлөгт нийцүүлэн зохион байгуулна.

17.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараа онд зохиогдох улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарийг 09 дүгээр сарын 30-аас өмнө албан ёсоор зарлах бөгөөд улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарийг гаргахдаа спортын холбооны саналыг авсан байна.

17.4. Орон нутгийн чанартай спортын тэмцээн зохион байгуулах тохиолдолд зохион байгуулагч нь тухайн сумын биеийн тамирын арга зүйч, дүүргийн Биеийн тамир, спортын газарт ажлын 10 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх бөгөөд сумын биеийн тамирын арга зүйч, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар, тухайн спортын төрлийн холбоонд мэдэгдэнэ.

17.5. Энэ хуулийн 17.4-т заасны дагуу тухайн спортын холбоо нь спортын тэмцээн зохион байгуулах дүрэм, стандартын талаар тухайн орон нутаг дахь салбар, эсхүл биеийн тамирын арга зүйчээр дамжуулан танилцуулж, хяналт тавина.

17.6. Энэ хуулийн 17.3-т заасан хуваарьт ороогүй улсын хэмжээний спортын тэмцээн, энэ хуулийн 17.4-т зааснаар урьдчилан мэдэгдээгүй орон нутгийн чанартай спортын тэмцээн зохион байгуулахыг хориглоно.

[Empty box]

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалаар батлагдсан “Спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээний зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу улсын хэмжээний спортын тэмцээн наадмын нэгдсэн зааварт тусгасны дагуу анхан шатны тэмцээнд сум, дүүргийн хэмжээнд түүнээс шалгарагсад аймаг, нийслэлийн шатны тэмцээнд энэ шатны тэмцээнээс шалгарагсад шигшээ тэмцээнд шалгаран оролцох зарчмаар зохион байгуулагдана. Багийн спортын төрлийн шалгаруулалт бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс шалгарч 5 бүсээс шалгарсан 16 багийн тоглолтоор шигшээ тэмцээний зохион байгуулж нь олон улсын тэмцээний жишиг дүрэм стандартыг баримтална.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тогтоолоор Олон улсын Олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадмын мөчлөгт нийцүүлэн улсын хэмжээний спортын наадам (цаашид “наадам” гэх)-ыг зохион байгуулахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тогтоолоор Улсын хэмжээний тэмцээн, наадам зохион байгуулах журам"-ыг батлуулж журмын дагуу 2019 онд Монгол Улсад зохион байгуулагдах Үндэсний хэмжээний спортын наадмуудыг өвөл, зуны Олимпын наадмын давтамжтай уялдуулан зохион байгуулж байна. Ингэснээр үндэсний шигшээ багийн сонгон шалгаруулалтыг шуурхай хийж, тамирчдын сургалт-дасгалжуулалт тасралтгүй үргэлжилснээр Олимпын наадамд гаргадаг амжилтаа ахиулах чухал ач холбогдолтой.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, 17.4, 17.5, 17.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

2021 онд зохион байгуулах улсын хэмжээний тэмцээнүүдийн хуваарийг спортын холбоодоос авч нэгтгэн, нэгдсэн хуваарийг биеийн тамирын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлуулан хуулийн хугацаанд аймаг орон нутагт чиглэл хүргүүлж, байгууллагын веб цахим хуудасны ил тод нүүрэнд нийтэлсэн.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын даргын 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/17 дугаар тушаалаар 2021 онд улсын хэмжээний спортын тэмцээний хуваарийг батлан Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын газар, хороодын дарга нарт Улсын хэмжээний аварга шалгаруулах тэмцээний батлагдсан нэгдсэн хуваарьт тусгагдсан спортын төрлөөр харьяа нутаг дэвсгэртээ спортын холбоод, түүний салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулах, арга хэмжээний гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган ажиллахыг үүрэг болгож Биеийн тамир, спортын тухай хуулийн 17.4 дахь заалтыг дагаж мөрдөж Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын 4.4 дэх заалтын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Улсын хэмжээний спортын наадам



зохион байгуулах жилд тухайн тогтоосон төрлийн насны ангиллаар Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутгийн болон улсын төсвөөр санхүүжүүлэхгүй болохыг дурдсан.

## **18 дугаар зүйл. Үндэсний шигшээ баг**

18.1. Үндэсний шигшээ баг нь өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн гэсэн ангилалтай байна.

18.2. Монгол Улсыг төлөөлөн Олимп, Паралимпийн наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлыг зохион байгуулалтаар хангах Үндэсний хороог Ерөнхий сайдын дэргэд байгуулж ажиллуулна.

18.3. Монгол Улсын нэрийн өмнөөс олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадамд оролцох үндэсний шигшээ багийг спортын холбоо бүрдүүлж, үйл ажиллагааг нь хариуцан зохион байгуулна.

18.4. Энэ хуулийн 9.1.8-д заасан журмын дагуу сонгосон спортын төрлийн спортын холбоонд гэрээний дагуу улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь спортын холбоотой Захиргааны ерөнхий хууль, холбогдох журмын дагуу гэрээ байгуулж, санхүүжүүлнэ.

18.5. Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 8-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна.

18.6. Оюутны дэлхийн аварга, Универсадад Монгол Улсыг төлөөлөн оролцох шигшээ багийг залуучуудын шигшээ багаас бүрдүүлнэ.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн А\167 тоот Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох санхүүжүүлэх журам батлагдаж, журмын дагуу Үндэсний шигшээ багийн сонгон шалгаруулалт зарлаж, спортын 22 төрөлд багш дасгалжуулагч, тамирчдын нийт 240 хүнээр шигшээ багаа бүрдүүлсэн. Өсвөрийн шигшээ багийг 21 аймаг, 9 дүүрэг нийт 30 байгууллагын Засаг даргын дэргэд спортын 8 төрөлд давхардсан тоогоор спортын 28 төрөлд шилдэг тамирчдын залгамж халаа болсон өсвөрийн 2250 гаруй тамирчдыг бэлтгэж байна. Залуучуудын шигшээ багийг Монголын Оюутны спортын холбоотой хамтран зохион байгуулан ажиллаж байна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол улсын Ерөнхий сайдын дэргэд Олимпын наадамд бэлтгэх үндэсний хороог байгуулж, 2018 онд Олимпын наадамд бэлтгэл ажлыг хангах чиглэлээр хэлэлцэх асуудал, 2018-2021 онд хэрэгжүүлэх календарьчилсан төлөвлөгөө,

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, “Олимп сан”-тай гурвалсан гэрээ байгуулахаар боловсруулаад байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны 2019 оны 4 сарын 3 өдрийн хурлаар Олимпын бэлтгэл ажлыг хангах чиглэлээр 2 тогтоол, 2019-2020 онд хэрэгжүүлэх календарьчилсан төлөвлөгөөг тус тус баталсан. Төлөвлөгөөний дагуу Олимпын эрхийн тэмцээн, дотоодын бэлтгэл цугларалтын хуваарь гаргаж бэлтгэл сургуулилт хийгдэж байна. Олимпын наадамд бэлтгэх Үндэсний хорооны хурлыг 9 сарын 25 өдөр хуралдуулж “Токио-2020” Олимпын болон Паралимпийн наадамд оролцох үндэсний шигшээ багийн бэлтгэл ажлын явц, төлөвлөгөөний биелэлт, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Мөн сонгон шалгаруулалтад шалгарсан “Токио-2020” Олимпын болон Паралимпийн наадамд оролцох Монгол Улсын багийн бүрэлдэхүүний өмсөх спортын болон ёслолын хувцасны танилцуулга хийгдэж уг загварыг баталгаажуулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, “Олимп сан”-тай гуравласан гэрээ байгуулж, Мишээл & Амазонка загварын агентлагт батламж гардууллаа. Гэрээ байгуулан захиалга хийгдсэн. Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны 2019 оны төлөвлөгөө хэрэгжсэн. Олимпын наадамд бэлтгэх үндэсний хорооны хурлыг 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор хуралдуулаагүй бөгөөд, дэд ажлын хэсгийг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 11 ний өдрийн А\88 тоот тушаалаар бүрэлдэхүүнийг баталж, 2020-2021 онд хийх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, Олимпод бэлтгэх Үндэсний хороонд танилцуулахаар ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

2020 оны байдлаар Үндэсний шигшээ багийн спортын 22 төрөлд дасгалжуулагч эрэгтэй 46, эмэгтэй 10, нийт 56, тамирчин эрэгтэй 123, эмэгтэй 93, нийт 216, бүгд 274 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид олон улсын 35 тэмцээнээс алт 6, мөнгө 12, хүрэл 28, нийт 46 медаль хүртсэн амжилттай байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А\167 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу спортын 22 төрөлд дасгалжуулагч эрэгтэй 46, эмэгтэй 10, нийт 56, тамирчин эрэгтэй 123, эмэгтэй 93, нийт 128, бүгд 274 хүний бүрэлдэхүүнтэй шигшээ багаа бүрдүүлж, 11 тэрбум батлагдсанаас 6.9 тэрбум төгрөгийг зарцуулан ажиллаа.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүрэгт спортын 28 төрлөөр Өсвөрийн шигшээ багт 284 дасгалжуулагч 6147 тамирчинтай ажиллаж байгаагаас 10 хүртэлх насныхан 15%, 10-14 насныхан 35%, 15-18 насныхан 50% бүрдүүлж байна. Тэд жилд 5 шатлал бүхий 1217 тэмцээнд 34124 тамирчин оролцож 3611 алт, 3554 мөнгө, 4500 хүрэл медаль хүртээд байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Залуучуудын шигшээ багийг Оюутны шигшээ багаас бүрдүүлэх бодлого барьж ажилладаг бөгөөд Оюутны дэлхийн аварга, Универсадад оролцож, өндөр амжилт үзүүлэн медальт байрт шалгарсан тамирчдад дэмжлэг үзүүлэхэд улсын төсвөөс үндэсний шигшээ багийн төсөвт суугдаагүй болно. Спортын холбоод Залуучуудын шигшээ багаа Оюутны шигшээ багаас бүрдүүлэн ажилладаг. Улсын төсвөөс залуучуудын шигшээ багт төсөв хуваарилагдаагүй болно.

**19 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир, спортын үйл ажиллагаа**

19.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход төрийн байгууллага, спортын холбоод дэмжлэг үзүүлж ажиллана.

19.2.Спортын тэмцээн, наадам нь хөгжлийн бэрхшээлтэй тамирчныг бие эрхтэн, хөгжлийн онцлогийн адил түвшинд нь өрсөлдүүлэх зарчмыг баримтална.

19.3.Энэ хуулийн 19.2-д заасан зарчмыг хангах зорилгоор улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг биеийн тамир, спорт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран 3 талт санамж бичгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын хороодтой /Монголын паралимпийн хороо, Монголын Дифлимбийн хороо, Монголын Тусгай олимпын хороо ТББ-ийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн зөв мэдээлэл, мэдлэг өгөх хандлагыг өөрчлөхөд чиглэсэн гурван тал хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Жилд дунджаар 4 олон улсын арга хэмжээнд оролцох нөхцөл бололцоогоор хангаж 16.1 сая – 127.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Дотооддоо хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх таатай нөхцөлийг бүрдүүлэн жилд 47 нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний арга хэмжээ зохион байгуулж 947.5 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын холбоод, хороодын багш дасгалжуулагчдын мэдлэг дээшлүүлэх цахим сургалтыг зохион байгуулсан.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын байгууллагаас тогтоосон спортын тэмцээн, наадамд оролцох ангиллын дагуу дотоодоо тэмцээн зохион байгуулж мөн олон тэмцээнд оролцож байна. Дотоодоо дагаж мөрдөх баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээн, наадамд оролцох ангиллыг гэрээ байгуулан орчуулж байна.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар 9,250,000 төгрөгийн санхүүжилт батлагдаж, “Бусдаар ажил гүйцэтгүүлэх 33 дугаар гэрээг Хүүхэд, залуучуудын хөгжлийн шинэ зуун авьяас төв төрийн бус байгууллагатай байгуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг биеийн тамирын хичээлээр засан сайжруулах нь” сургалтын модуль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр засан сайжруулах нь” арга зүйн зөвлөмжийг боловсруулан 500 ширхгийг хэвлүүлэн спортын холбоодод хүргэсэн.

**20 дугаар зүйл. Тамирчны эрх, үүрэг**

- 20.1.Тамирчин нь доор дурдсан эрх эдэлнэ:
  - 20.1.1.спортын төрлөө сонгох, хичээллэх;
  - 20.1.2.тэмцээн, наадамд оролцох;
  - 20.1.3.спортын цол, зэрэг авах;
  - 20.1.4.харьяалагддаг спортын клубээс гэрээний дагуу өөр спортын клубт шилжих;
  - 20.1.5.спортын тэмцээнд бэлтгэх, оролцох хугацаанд үндсэн ажил, сургуулиас чөлөөлөгдөх;
  - 20.1.6.хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 20.2.Тамирчин нь доор дурдсан үүрэг хүлээнэ:
  - 20.2.1.тамирчны ёс зүйн дүрэм, оролцож буй тэмцээний дүрэм болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
  - 20.2.2.шударга өрсөлдөөнийг эрхэмлэх, допинг хэрэглэхгүй байх;
  - 20.2.3.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.
- 20.3.Тамирчин нь доор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:
  - 20.3.1.тамирчин Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадам, болон үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртвэл энэ хуулийн 6.1.6-д заасан мөнгөн шагнал авах;
  - 20.3.2.харьяалах байгууллагаас цалин хөлс, урамшуулал авах.


**Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогод тусгасны дагуу спортоор хичээллэх гэж буй иргэн нь өөрийн сонирхсон спортын төрлөө сонгон

хичээллэх эрхтэйгээс гадна Биеийн тамир, спортын газрын даргын 2018 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/192 дугаар тоот тушаалаар баталсан “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол зэрэг олгох журам”-аар зохицуулж байна. Мөн мэргэжлийн тамирчдын дунд клуб хооронд шилжих хөдөлгөөн ихсэж байгаа бөгөөд үүнийг тухайн спортын холбоодын тамирчны шилжих хөдөлгөөний журмын дагуу шийдвэрлэж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 173 дугаар тогтоол “Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулдаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”, “Үндэсний хэмжээний тэмцээн наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам ”-д заасны дагуу тэмцээн наадамд оролцож, гаргасан амжилтаа үнэлүүлэн спортын цол зэргийн болзлыг хангах спортын цол зэргийг авч байна, үзүүлсэн амжилтыг үнэлэн сайшааж мөнгөн урамшууллыг олгож байна.



**Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Эрүүл мэндийн сайд, сангийн сайдын хамтарсан 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Спортын их наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах, санхүүжүүлэх журам”-ын дагуу спортын тэмцээнд бэлтгэх, оролцох хугацаанд үндсэн ажил, сургуулиас чөлөөлөгдөх тэмцээнд оролцож чөлөөтэй байх үеийн цалинг бодож олгохыг зохицуулж байна.

## **21 дүгээр зүйл. Допингийн эсрэг үйл ажиллагаа**

21.1.Тамирчин нь Олон улсын допингийн эсрэг агентлагаас баталсан допингийн хориглосон жагсаалтад багтсан бодис, аргыг хэрэглэхийг хориглоно.

21.2.Дасгалжуулагч, багийн эмч нь тамирчинд допинг хэрэглүүлэхийг хориглоно.

21.3.Допингийн эсрэг үндэсний дүрмийг Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

21.4.Допингийн эсрэг үндэсний дүрмийн дагуу хэрэгжүүлэх ажлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

21.5.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, спортын холбоо бусад төрийн болон төрийн бус байгууллага нь хориглосон жагсаалтад багтсан бодис, аргууд, допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 391 дүгээр тогтоолын дагуу Монголын Үндэсний допингийн эсрэг байгууллагатай гэрээ байгуулан жил бүр улсын төсвөөс 2020 онд 455 сая төгрөгийн санхүүжилт олгон допингийн хор холбогдол, хориотой жагсаалтын талаарх сургалт сурталчилгааг жил бүр зохион байгуулж “Хориотой бодисын жагсаалт”, эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандарт”, “хувийн нууц ба хувийн мэдээллийг хамгаалах”, “лабораторийн олон улсын стандарт”, “шинжилгээний болон шалгалтын олон улсын стандарт”, “Допингийн олон улсын хууль” зэрэг олон улсын баримт бичгийг орчуулан гарын авлага болгон гаргаж спортын холбоод болон орон нутгийн Биеийн тамир, спортын газруудад тарааж сурталчилсан.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Допингийн эсрэг үндэсний дүрмийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан хэлэлцүүлэг зохион байгуулан ажиллаж байна. Допингийн эсрэг үндэсний дүрмээр Үндэсний платформ байгуулах зохицуулалтыг хийн ажиллах чиг үүргийг тодорхойлно.

## **22 дугаар зүйл. Спортын цол зэрэг**

22.1. Спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тамирчинд олгох олон улсын хэмжээний мастер, спортын мастер, дэд мастер цол, спортын шүүгчид олгох улсын шүүгч цолны шалгуурыг тогтоож, олгоно.

22.2. Спортын цол авсан тамирчин, спортын шүүгчид харьяалах байгууллага нь мөнгөн урамшуулал болон цолны нэмэгдэл олгож болно.

22.3. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй тамирчин, шүүгчид спортын цол олгоно.

22.4. Тамирчин, спортын шүүгчид спортын зэргийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх авсан спортын холбоо тогтоож, олгоно.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**


Биеийн тамир, спортын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/192 дугаар тушаалаар “Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол, зэрэг олгох журам”-аар тогтоосон. Спортын цол авсан тамирчин, спортын шүүгчид харьяалах байгууллага нь мөнгөн урамшуулал болон цолны нэмэгдэл олгож болно гэсэн хуулийн заалтыг үндэслэн байгууллагын дотоод журамдаа тусган мөнгөн урамшуулал олгож байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Спортын цол, зэргийн зөвлөлийг 2020 оны 1 сарын А/08 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнээр шинэчлэн баталж, Цол зэргийн зөвлөлийн хуралдаанаар цол зэргийн ангилалд нэмэлт 9 спортын төрлийн ангиллыг Даргын 2020 оны 1 сарын 20 өдрийн А/24 дугаар тушаалаар шинэчлэн тогтоосон. Төрийн байгууллагын цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх болон тэдгээрийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-mongolia-д холбох талаар үе шаттай ажлуудын төлөвлөлтийн дагуу 2022 онд спортын цол зэргийн нэгдсэн мэдээллийн сан болон спортын цол зэргийн лавлагааг авдаг болох ажлын бэлгэл ажлыг ханган ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/192 дугаар тушаалаар Спортын төрөл, цолны шалгуур тогтоох, цол, зэрэг олгох журам”-аар тогтоосон. Спортын цол, зэргийн зөвлөлийг 2020 оны 1 сарын А/08 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнээр шинэчлэн баталж, Цол зэргийн зөвлөлийн хуралдаанаар цол зэргийн ангилалд нэмэлт 9 спортын төрлийн ангиллыг Даргын 2020 оны 1 сарын 20 өдрийн А/24 дугаар тушаалаар шинэчлэн тогтоосон. Цол зэргийн tsol.gov.mn мэдээллийн нэгдсэн санд доорх тамирчин, шүүгчид бүртгэгдээд байна.



**Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дөх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Тамирчин, спортын шүүгчид спортын зэргийг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх авсан спортын холбоо тогтоож, олгож байна.

**23 дугаар зүйл. Мэргэжлийн спорт**

23.1.Ашиг олох зорилгоор мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн тамирчны оролцоотой мэргэжлийн спортын тэмцээн зохион байгуулж болно.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Олон улсад мэргэжлийн спортын холбоодод албан ёсоор элсэхэд татвар өндөр байдаг тул манай тулааны спортоор хичээллэж байгаа зарим тамирчид хувийн шугамаар гэрээ байгуулан өнөөдрийг хүртэл дэлхийн тавцанд өрсөлдөж байгаа болно гэсэн асуудал хариуцсан мэргэжилтний тайланг үндэслэв.



## **ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ 4**

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 дугаар бүлэг.**

*“Биеийн тамир, спортын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, төрөөс уг салбарыг зохицуулах арга зам, тэдгээрийн хэрэгжилт”*

### **Шалгуур үзүүлэлт**

*Зорилгод хүрсэн түвшин - /тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэх/*

### **Харьцуулах хэлбэр**

*Байх ёстой болон одоо байгаа-хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар*

### **Шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал**

*Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь зорьсон зорилгодоо хүрсэн эсэх*

### **Үнэлсэн байдал**

#### **24 дугаар зүйл. Биеийн тамир, спортын санхүүжилт**

24.1.Энэ хуулийн 6.1.4, 6.1.6 дахь заалт, 17.2, 18.4, 22.1, 26.2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

24.2.Энэ хуулийн 7.1.1, 8.1.3, 8.1.4 дэх заалт, 18.5, 26.6 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг орон нутгаас санхүүжүүлнэ.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Монгол улсад зохион байгуулах олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээний жагсаалтын дагуу 2018 онд 12 төрлийн тэмцээн наадамд 1,1 тэрбум төгрөг, 2019 онд спортын 13 төрлийн тэмцээн наадамд 1,3 тэрбум төгрөг, 2020 онд спортын 25 төрлөөр олон улсын залуучуудын спортын ногоон наадамд 9,6 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа хэдийн цаг үеийн байдлаас шалтгаалан хойшлогдоод байна.

Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадмын мөчлөгт нийцүүлэн зохион байгуулдаг улсын хэмжээний спортын наадам болох Үндэсний спортын наадмыг 2018 онд зохион байгуулан 337,2 сая төгрөг, 2019 онд хүүхдийн спортын наадамд 449,8 сая төгрөг, Бүх ард түмний өвлийн спортын наадмыг 192,5 сая төгрөг, 2020 онд Оюутны спортын наадамд 186,9 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.

Үндэсний шигшээ багт 2018 онд спортын 17 төрөлд 5,031 тэрбум төгрөг, 2019 онд спортын 16 төрөлд 5,982 тэрбум төгрөг, 2020 онд спортын 22 төрөлд 6,9 тэрбум төгрөгийг төсөв зарцуулаад байна.

Спортын цол зэргийн тэмдэг, үнэмлэхийн зардалд 2018-2020 онд жил бүр 30,0 сая төгрөг зарцуулаад байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Спортлог Дарханчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн төсвийн 145 сая төгрөг, Дархан сумын орон нутаг хөгжил сангийн 8.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймаг, сумын ЗДТГазар, аймгийн Хоккейн холбоо хамтран олон улсын стандартад нийцсэн хоккейн талбай байгуулагдаад байна. Олон улсын стандартад нийцсэн хөлбөмбөг, хөнгөн атлетикийн талбай барьж байгуулах ажилд орон нутаг хөгжил сангаас 1.6 тэрбум төгрөгийн төсвийн санхүүжилттэй ажил үргэлжилж байна.



**Биеийн тамир, спортын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 24.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг аймаг, дүүргийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж, жилд дунджаар 2.0 – 30.0 хүртлэх сая төгрөгийн төсөв хөрөнгийг баталуулж үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр спортын шилдэгүүдийг шалгаруулах журмыг хэрэгжүүлэн спортын шилдэг тамирчин, шилдэг хамтлаг, шилдэг холбоо, шилдэг дасгалжуулагч, шилдэг баг, шилдэг ивээн тэтгэгч, шилдэг холбооны тэргүүнийг шалгаруулан урамшуулж байна. Мөн Олон улс тив дэлхий, улс, чанартай тэмцээн, наадмаас медаль авсан тамирчин дасгалжуулагч болон дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэж иргэдийн дунд зохион байгуулсан арга хэмжээнд идэвхи санаачлагатай, үлгэрлэн оролцсон иргэдэд урамшуулал дэмжлэг үзүүлэн жилд дунджаар 0.8 – 35.637.0 хүртлэх сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулж байна. Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 60 суманд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллаж байна. Тэдгээрийг төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээний шатлалын ТҮ-6-1-ээр цалинжуулан ажиллаж байна. Аймаг, дүүргийн Засаг дарга нь өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар нь спортын 6-14 төрлөөр өсвөрийн шигшээ багийг бүлдүүлэн спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран үйл ажиллагааг нь зохион байгуулж жилд дунджаар 2.9 – 119.013 сая төгрөгийн санхүүжилтийг залцуулан ажиллаж байна.

## **25 дугаар зүйл. Биеийн тамир, спортын үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэг**

25.1.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь спортын холбоо, спортын клуб, биеийн тамирын арга хэмжээ, спортын тэмцээн, наадмыг ивээн тэтгэж болно.

25.2.Аж ахуйн нэгж, байгууллагын спортын заал, талбай түүний дэд бүтцийг барих, спортын хэрэглэл, тоног төхөөрөмжийг улсын хилээр нэвтрүүлэхэд төрөөс татварын дэмжлэг үзүүлнэ.

25.3.Энэ хуулийн 25.2-т заасан татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг татварын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Аж ахуй нэгж, байгууллага, иргэн нь спортын холбоо, клуб, тамирчдыг биеийн тамирын арга хэмжээ болон спортын тэмцээн, наадамд оролцоход эд материалын болон мөнгөн тусламж, дэмжлэг үзүүлж байна. Ингэснээр спортын холбоо, клубийн үйл ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудал мөн тамирчдын тэмцээн, наадамд оролцож амжилт ахиулах нөхцөл боломж нэмэгдэж байна. Аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн ивээн тэтгэлгийн мөнгөн тусламжийн тоо хэмжээг татварын ерөнхий газартай хамтран жил бүрээр гаргах ажлыг эхлүүлээд байна.

### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Биеийн тамир, спортын тухай хуулийг дагалдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.5.5 дахь хэсгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулан биеийн тамир, спортыг үйл ажиллагаанд 10 сая хүртэлх төгрөгийн хандив өгсөн, спортын барилга байгууламж, спортын заал, талбай, дэд бүтцийг барьж байгуулсан аж ахуйн нэгж тухайн спортын барилга байгууламж, спортын заал, талбайг ашиглаж эхэлснээс хойш 5 жилийн хугацаанд ашиглалтын үйл ажиллагаанаас олсон 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг хөнгөлөх эрх зүйн орчин бүрдүүлсэн. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.19 дахь хэсэгт “спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэл”-ийг гаалийн татвараас чөлөөлдөг болсон.

Иргэд биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, спортын холбоо, клубийн спортын тоног, төхөөрөмж хэрэглэл материалын хангалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн “Гаалийн татвараас чөлөөлөгдөх спортын зориулалтын тоног, төхөөрөмж хэрэглэлийн жагсаалт батлах тухай” 247 дугаар тогтоолоор нийт 32 спортын төрлийн 701 нэр төрлийн тоног, төхөөрөмж хэрэглэлийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан. Уг тогтоолын хүрээнд 2020 онд 46 аж ахуйн нэгж, 5 иргэний импортолсон нийт 2,8 сая ам.долларын үнэ бүхий спортын зориулалттай тоног, төхөөрөмж, хэрэглэлд ногдох 379,2 сая төгрөгийг гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.

## **26 дугаар зүйл. Биеийн тамир, спортын барилга байгууламж**

26.1.Спортын барилга байгууламж, заал, талбай нь стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

26.2.Спортын барилга байгууламж, заал, талбайн стандартыг боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

26.3.Биеийн тамир, спортын барилга байгууламж, заал, талбай нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байна.

26.4.Төрийн болон орон нутгийн өмчлөлийн спортын барилга байгууламж, заал, талбайн зориулалтыг өөрчлөхийг хориглоно. Хувьчлах болон тухайн барилга байгууламж, заал, талбайг буулгаж, шинээр барих тохиолдолд биеийн тамир, спортын зориулалтыг хэвээр хадгална.

26.5.Сургуулийн өмнөх, ерөнхий, дээд, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллага нь суралцагчийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх стандартын шаардлага хангасан барилга байгууламж, заал, талбайтай байх нөхцөлийг бүрдүүлнэ.

26.6.Хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар баригдсан, стандартын шаардлага хангасан спортын барилга байгууламж, спортын зааланд иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж болно.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Засгийн газраас спортын барилга байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлд анхаарал хандуулж 2017-2020 онд 83 спортын цогцолбор, заалыг улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл сайжирч, тоон үзүүлэлт нэмэгдэж байна. 2020 оны эцсийн байдлаар Монгол Улсад өмчийн бүх хэлбэрийн 686,880.0 м.кв талбай бүхий 1068 спортын заал, 3360288 м.кв талбай бүхий 852 спортын гадаа талбай үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 2020 онд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нийслэл 17, баруун бүс 13, хангайн бүс 12, төвийн бүс 15, зүүн бүс 5 биеийн тамир, спортын байгууламж, гадна талбай ашиглалтад орсон. Эдгээр барилга, байгууламж, талбай ашиглалтад орсноор нэг хүнд ногдох спортын заалны талбайн хэмжээ 0,25 м.кв, гадна талбай 1,25 м.кв болсон бөгөөд уг төрөөс баримтлах бодлогын 2023 онд гаргах шалгуур үзүүлэлтэд хүрсэн болно.

Биеийн тамир, спортын салбарт 2016-2020 оны хугацаанд хөнгөн атлетик, битүү дээвэртэй мөсөн ордон зэрэг олон улсын стандарт шаардлагыг хангахуйц спортын барилга байгууламжийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах ажлыг эхлүүлсэн. Үүнд:

Нийслэлийн Налайх дүүрэгт байрлах Монгол Улсад анхны олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн 400 метрийн тойрог зам, зээрэнцэг, бөөрөнцөг, жад, дүүгүүр, харайлтын талбай талбай бүхий 2.3 тэрбум төгрөгийн өртөгтэй байгууламжийг Олон улсын хөнгөн атлетикийн холбоо, Монголын хөнгөн атлетикийн холбоотой хамтран 2018 онд барьж ашиглалтад оруулсан.

Завхан аймгийн Улиастай суманд 400 хүний суудалтай усан бассейн, 500 хүний суудалтай спорт заал, жүдо, самбо бөх, гимнастик болон бүх төрлийн спортоор хичээллэх бэлтгэлийн заалтай, иж бүрэн агааржуулалтын системтэй, усан халаалттай 7.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй усан бассейн бүхий спорт цогцолборыг 2018 ашиглалтад оруулсан.

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт Монголын анхны олон улсын стандартад нийцсэн битүү дээвэртэй 200 үзэгчдийн суудалтай, 60м х 30м мөсөн гулгуурын талбай, 25 метрийн бассейн бүхий цогцолборыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Нийслэлийн Хан-Уул дүүрэгт 2,600 хүртэлх үзэгчийн суудалтай, 60м х 30м мөсөн гулгуурын талбайтай бүхий “Мөсөн өргөө” өвлийн спортын ордныг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барьж байгаа бөгөөд 2021 оны эхний хагас жилд бүрэн ашиглалтад оруулна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**


Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 53 дугаар тогтоолоор батлагдсан Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техник шаардлага MNC 5682:2006 стандартын дагуу спортын барилга, байгууламжийн орц, гарцын хэсгийг тохижуулан хөгжийн бэрхшээлтэй иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалж, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг асуудлыг шийдэн ажиллаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Төрийн болон орон нутгийн өмчлөлийн спортын барилга байгууламж, заал, талбайг хуулийн дагуу өөрийн зориулалтаар нь ашиглаж байна.

**Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**


Сургуулийн өмнөх, ерөнхий, дээд, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллага нь суралцагчийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх стандартын шаардлага хангасан барилга байгууламж, заал, талбайтай байх нөхцөлийг бүрдүүлэн доорх спортын барилга байгууламж, заал талбайг ашиглаж байна.



**Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

Хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар баригдсан, стандартын шаардлага хангасан спортын барилга байгууламж, спортын зааланд иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх зорилгоор баригдсан заал талбайн үзүүлэлт.

## ХУВИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДСАН СПОРТ ЗААЛ



### 27 дугаар зүйл. Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

27.1.Биеийн тамир, спортын хууль тогтоомжийн биелэлтэд бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

27.2.Талууд гэрээнд маргааныг арбитраар шийдүүлэхээр харилцан тохиролцсон, шүүхийн харьяаллын бус бусад спортын үйл ажиллагаатай холбоотой маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлнэ.

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 27.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

#### **Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 27.2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд:**

### 28 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

28.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

